



ХЭНТИЙ АЙМГИЙН  
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 01 сарын 07 өдөр

Дугаар 4/03

Дэлгэрхаан сум

Өмч хамгаалах байнгын зөвлөл  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.1, 31.4 дэх хэсэг, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 05 дугаар сарын 25-ны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын өмч хамгаалах байнгын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Зөвлөлийн дарга: -Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

-Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн

-Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн

-Тамгын газрын нягтлан бодогч

- Сан, ТҮК хариуцсан нягтлан бодогч

Нарийн бичгийн дарга: -Архив, бичиг хэргийн ажилтан

2.Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг боловсруулж батлуулан, хагас бүтэн жилээр хэрэгжилтийг хангаж ажилласан тайланг танилцуулж ажиллахыг зөвлөлийн дарга, гишүүдэд даалгасугай.

3.Засаг даргын Тамгын газрын хөрөнгөд гарсан өөрчлөлт хөрөнгийн хадгалалт хамгаалалт бүрэн бүтэн байдлыг байнга шалгаж эд хөрөнгийн тооллогоор шилжүүлсэн, худалдсан, актлах хөрөнгийг өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар хэлэлцэн дүгнэлт гаргаж, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 04 дүгээр тогтоолуудыг мөрдлөг болгон ажиллахыг өмч хамгаалах байнгын зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА

Д.УРАНГОО



2336070005

